



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/565

Алтай хот

Сургалтад оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журмын 4.1.1, 4.1.5 дахь заалтууд, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 3.1.3 дэх заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны 1а/2525 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн албаны тухай хууль болон Дайчилгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Баруун бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын дарга нартай явуулах "Цэргийн бэлтгэл" сургалтад сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг оролцуулсугай.


2. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг Хилийн цэргийн 0130 дугаар анги болон тус ангид хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн алба хаагчдын үйл ажиллагаатай танилцуулах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб (хурандаа Д.Төмөрбаатар)-т даалгасугай.

2. Шаардагдах зардал 4,000,180 (дөрвөн сая нэг зуун наян) төгрөгийг цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогоос гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


4. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг бүрэн хамруулж оролцуулах, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20²² оны 09
дугаар сарын 06 -ны өдрийн А/505 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зарцуулах зүйлийн нэр	Материал хэрэгслийн тоо хэмжээ,	Зардал	Нийт зардал
1	Ховд- сургалтын төв- Үенч-Есөнбулаг сумд ирэх шатахууны зардал /2 нэгж техник/	1370 км 274 л 1370 км 274 л	2680 төгрөг 3890 төгрөг	734.320 төгрөг 1.065.860 төгрөг
2	Сургалтын материал хэрэгсэл		1.000.000 төгрөг	1.000.000 төгрөг
3	Байр, хоолны зардал		1.200.000 төгрөг	1.200.000 төгрөг
4	Нийт		4.000.180 төгрөг	

__оОо__